



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№227 /436/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.12.15

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ, ЯПОНЫ БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭНД...



Монгол Улсаас Япон Улсад суугаа ЭСЯ-нд энэ сарын 13-ны өдөр хоёр улсын дипломат харилцааны 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монгол, Японы батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгууллаа.

Гэрэл зургийн үзэсгэлэнд Япон талаас БХЯ-ны Гадаад харилцаа хариуцсан дэд сайд М.Ока болон холбогдох албан тушаалтнууд, Монгол

талаас Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Батжаргал, Элчин зөвлөх С.Болорчимэг, Батлан хамгаалахын атташе, хурандаа Л.Энхбат, Япон Улсын цэргийн сургуульд суралцагч Монгол Улсын цэргийн албан хаагчид оролцлоо.

Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Батжаргал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ хоёр орон цэргийн

салбарт хамтран ажиллах нь бүс нутгийн хэмжээнд цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтойг тэмдэглээд цаашид Монгол, Японы Тусгай Стратегийн түншлэлийн хөтөлбөрт батлан хамгаалахын чиглэлээр тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, Монгол Улс, Япон Улсын батлан хамгаалах салбарын харилцааг шинэ шатанд ахиулж хөгжүүлэх, олон улс, бүс нутгийн асуудлаар харилцан ажиллагааг үргэлжлүүлэн, Зүүн хойд Азийн бүс нутаг дахь энх тайван, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хамтран ажиллахад бэлэн байгааг онцлон дурдав.

Дараа нь Япон Улсын БХЯ-

ны Гадаад харилцаа хариуцсан дэд сайд М.Ока арга хэмжээг зохион байгуулж буй ЭСЯ-ны бүрэлдэхүүн, нийт оролцогчид талархал илэрхийлж, цаашид ч хоёр орны стратегийн түншлэлийн харилцаа, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үр бүтээлтэй хамтран ажиллах байр суурьтай буйгаа илэрхийллээ.

Нээлтийн дараа Япон Улсын Үндэсний батлан хамгаалах академид суралцагч Монгол Улсын сонгогчид уригдан ирсэн зочид төлөөлөгчдөд сургуулийн танилцуулга болон жагсаалын үзүүлэх тоглолт хийж толилууллаа. Мөн энэ үеэр "Их татлага" үндэсний хөгжмийн хамтлаг ардын хөгжмийн уран тансаг аялгуугаа бие бүрэлдэхүүнд тоглож сонирхуулсан юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-19	-30

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.448	3.452
EUR	3.675	3.690
CNY	493	496
RUB	52.20	52.50
JPY	25.50	25.70
KRW	2.65	2.67

ЗУРХАЙ

2022.12.15 / ПҮРЭВ ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 22

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ХАР
БАР ӨДӨР

Үс засуулбал:

Идээ ундаа элбэг олдоно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.35-17.00

БАРИЛДЛАГА:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Төрөн түгэхүй

ЦЭРГИЙН БАГ ҮҮРГЭЭ БИЕ ДААН ГҮЙЦЭТГЭЖ ЭХЭЛЛЭЭ



Эдгээр өдрүүдэд БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийг ажиллагааны газар оронд шилжүүлэх ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж байна.

Цэргийн багуудын ээлжийг хүлээлцүүлэхээр Монгол Улсын Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд энэ сарын 13-ны өдөр НҮБ-ын туг, Монгол Улсын Төрийн далбаа, цэргийн багийн тамга, үүрэг гүйцэтгэлтийг

шилжүүлэх ёслолын ажиллагааг зохион байгуулсан юм.

Уг ёслолын ажиллагаанд ажлын хэсгийн ахлагч, Батлан хамгаалахын яамны Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, НҮБ-ын "UNMISS" ажиллагааны Юнити секторын командлагч бригадын генерал Майк Купер Мужуни болон тус секторт үүрэг гүйцэтгэж буй цэргийн багуудын удирдлага, албаны хүмүүс, ээлж хүлээлцүүлэх ажлын хэсэг, цэргийн багуудын бие бүрэлдэхүүн оролцлоо.

Энэ үеэр ажлын хэсгийн ахлагч, Батлан



хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ Монгол цэргийн энхийг сахиулах үүргийг амжилттай гүйцэтгэж ирсэн сайхан уламжлалыг түүчээлэн, Монгол цэрэг дэлхийн цэрэг хэмээх алдрыг бататган амжилттай үүргээ гүйцэтгэн эх орондоо ирэхийг хүсэн ерөөсөн юм.

Ийнхүү Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын "UNMISS" ажиллагаанд үүргээ бие даан гүйцэтгэж эхэллээ.

Хошууч М.ТҮМЭНЖАРГАЛ

ЦЭРГИЙН АЛБА, САХИЛГЫН ЗӨРЧИЛГҮЙ НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГА ШАЛГАРУУЛНА



Энэ онд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын баталсан удирдамжийн дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, ажлын үр дүнг тодорхойлох зорилгоор "Цэргийн алба, сахилгын зөрчилгүй тэргүүний нэгтгэл, анги, байгууллага" шалгаруулах болзолт уралдааны зарласан билээ.

Тэгвэл тус уралдааны I шатанд Зэвсэгт хүчний 015, 124, 256, 331, 338, 353 дугаар ангиуд амжилттай оролцож дараагийн шатны

шалгаруулалтад оролцох эрхээ авчээ. Уралдааны II шатны шалгаруулалтыг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан комиссын бүрэлдэхүүн энэ сарын 12-ноос 28-ны өдрүүдэд дэнслэн явуулах бөгөөд одоогоор Зэвсэгт хүчний 353, 015 дугаар ангиудад тус тус ажиллаад байна.

Цаашид шалгаруулалтыг удирдамжид заагдсан хуваарийн дагуу зохион байгуулж уралдааны дүнг уламжлал ёсоор Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтын үеэр танилцуулж, шагналыг гардуулан өгнө.

Ахмад Б.ЖАВХЛАНТӨГС

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 655,575,160

Эдгэрсэн

Нийт: 630,250,487

Нас барсан

Нийт: 6,664,478

